



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 116


Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн нэгдүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Батбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /О.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
01 дүгээр сарын 16 ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

4/16

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Баянзүрх дүүрэг, Энх энэрэл өрхийн эрүүл мэндийн төв	01/2025	3 жил	2025.01.12	2028.01.12
2.	Баянзүрх дүүрэг, Эрүүл Оршихуй өрхийн эрүүл мэндийн төв	02/2025	3 жил	2025.01.12	2028.01.12
3.	Хан-уул дүүрэг, Хашчагнуур өрхийн эрүүл мэндийн төв	03/2025	2 жил	2025.01.12	2027.01.12
4.	Хан-уул дүүрэг, Амгалан-Оргил өрх өрхийн эрүүл мэндийн төв	04/2025	1 жил	2025.01.15	2026.01.15
5.	Улаанбаатар хот, Асралт мед ХХК-ийн эмнэлэг	05/2025	2 жил	2025.02.11	2027.02.11
6.	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн харьяа Дарь эх нэгдсэн эмнэлэг	06/2025	1 жил	2025.01.15	2026.01.15
7.	Улаанбаатар хот, ШШГЕГ-ын харьяа Хорих 401 дүгээр анги	07/2025	1 жил	2025.01.15	2026.01.15
8.	Улаанбаатар хот, Манал-Оточ ХХК-ний эмнэлэг	08/2025	1 жил	2025.01.15	2026.01.15
9.	Улаанбаатар хот, Альфа медиал центр ХХК-ийн эмнэлэг	09/2025	2 жил	2025.01.15	2027.01.15
10.	Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв	10/2025	2 жил	2025.01.20	2027.01.20
11.	Сэлэнгэ аймаг, Сайхан сумын эрүүл мэндийн төв	11/2025	2 жил	2025.01.20	2027.01.20
12.	Сэлэнгэ аймаг, Хүдэр сумын эрүүл мэндийн төв	12/2025	2 жил	2025.01.20	2027.01.20
13.	Төв аймаг, Лүн сумын эрүүл мэндийн төв	13/2025	2 жил	2025.01.20	2027.01.20